



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 27 өдөр

Дугаар А/402

Чингис хот

Монгол тайга нохой бүхий талын гөрөөчдийн
өв соёл” видео контент, шторк, онлайн сэтгүүл
бэлтгэхэд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Аялал жуулчлалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.1, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20 дахь заалтууд, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан “Тайга нохойн наадам” эвент арга хэмжээний хүрээнд талын гөрөөчдийн өв соёл, уламжлалыг дотоод, гадаадын жуулчид, хүүхэд залууст таниулан сурталчлах, соёлын биет бус өвийг хадгалж хамгаалах, үр хойчдоо уламжлуулан үлдээх зорилгоор видео контент нэвтрүүлэг, шторк, онлайн зурагт сэтгүүл бэлтгэх ажилд хөрөнгө зарцуулсугай.

2. Зарцуулах хөрөнгийн тооцоог хавсралт зар баталсугай.

3. Шаардлагатай үнэ 2,000,000 (хоёр сая) төгрөгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Нямдаваа)-т, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ж.Ганбаатар)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231011939

Аймгийн Засаг даргын 2021 оны
...08 дугаар сарын 25 өдрийн А/Н.О.Д
дугаар захирамжийн хавсралт

Зардлын тооцоо

д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ /төгрөг/
1	Видео контент нэвтрүүлэг	ш * мин	1 * 15'-20'		1,000,000
2	Шторк	ш * мин	2 * 1'-1'5"		500,000
3	Онлайн зурагт сэтгүүл	ш	1		500,000
	Нийт				2,000,000